



## “ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 дүгээр  
Сарын 14-ний өдөр

Дугаар ХЭХ03/03

Улаанбаатар  
хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон Хараат бус гишүүдийг шинээр сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.7, 67 дугаар зүйлийн 67.3.8, 77 дугаар зүйлийн 77.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

- 1) Ц.Баатарсайхан
- 2) Д.Хулан
- 3) Ч.Ванчин-Эрдэнэ
- 4) Ц.Оюунцэцэг
- 5) Ц.Цэцэнхүү
- 6) Ц.Оргилболд

2. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

- 1) Я.Пүрвээ
- 2) Д.Байгалмаа
- 3) В.Хүрэлхад

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд нь гишүүний үүргээ хууль болон компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх, компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж, шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д тус тус холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Ё.Ганбат-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ВАНЧИН-ЭРДЭНЭ